

Уламжлалт анагаах ухаанд хэрэглэдэг цөсний өвчний жор найрлагад дүн шинжлэл хийсэн нь

Хунаа (Zhao zhi hong)¹, О.Мөнхчимэг², Б.Шилэнцэцэг³, Ч.Батнайрамдал²

¹АШУУИС, МАУОУС, Дотор Өвчин Судлалын Тэнхим

²АШУУИС, Монгол Анагаах Ухааны Төв Эмнэлэг

³БНХАУ, ӨМӨЗО, Анагаах Ухааны Их Сургууль

Цахим шуудан: btd24ee009@gt.mn.ums.edu.mn, Утас: 85153367

Түлхүүр үг:

Цөсний халуун
өвчин
Цөсний хүйтэн
өвчин
Тайлбар бүтээл
Дан эм
Эртний
сурвалж бичиг

Товч утга:

Үндэслэл: Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас мэдээлснээр жил ирэх тусам дэлхийн хүн амын цөсний өвчлөл нэмэгдсээр байна. АНУ-д цөсний хүүдийн цочмог үрэвсэлтэй тохиолдлын 90%-д цөсний хүүдийн гарах хэсэгт, Хартманы уутны хэсэгт саад үүссэн, үлдсэн 10%-д нь чулуугүй цөсний хүүдийн цочмог үрэвсэл тохиолддог байна. Монгол улсын хүн амын 2019 оны Эрүүл мэндийн үзүүлэлтээр хоол боловсруулах тогтолцооны өвчлөлийн 2 дугаарт орж цөсний хүүдий, цөсний зам ба нойр булчирхайн өвчин 14.2%-ийг эзэлж дээрх өвчлөлтэй хамааралтай мэс заслын эзлэх хувь өндөр байна. Уламжлалт анагаах ухааны тулгуур бичиг “Анагаах Ухааны Дөрвөн Үндэс”-ийн Онолын Үндэст өвчин эмгэгийг анагаах ерөндөг нь: явдал мөр, идээ ундаа, эм, засал гэж дөрөв бий хэмээсэн. Биеийн эрүүл ахуйд тустай идээ явдлыг тэнцүүлэхэд анхаарал тавьж байвал өвчин үүсэхгүй гэдэг. Уламжлалт анагаах ухааны сурвалж бүтээлүүдэд цөс нь шарын ерөнхий оронд оршино. Үүнд цөс нь шарын ерөнхий оронд оршиж, шингээгч шарын гол орон мөн. Цөсний шингэн нь цөсний цоргоор дамжин 12 хуруу гэдсэнд ордог нь орчин үеийн анагаах ухааны онолтой дүйцэж байна. Иймээс цөсний гол үйл ажиллагаа нь тунгалаг цөвийн ялгаралтад оролцож, шингээлтийн гурван хүчний голлогч болж, идээ ундааг шингээж, биеийн илчийг ихээр үүсгэнэ. Эм найрлага нь хий шар бадганы сургаал ба таван махбодын сургаалаар удирдамж болгож, өвчнөөс урьдчилан сэргийлэх,

анагаах зэрэг бүхэл цогц үзлийг баримталж эмчлэхэд гол үйлдэл үзүүлж буй юм. Өвчний байдлыг үндэслэн эм хэрэглэх арга зам нь эм уулгах, эм шавах, эм түрхэх, эмээр угаах, шулуун гэдсээр эм тавих, эм дусаах, эмээр зайлах, эм соруулах, эмээр утах, дэвтээлгэ, жин тавих, улиралтайгаа тохируулан хэрэглэх, цагийг тохируулан хэрэглэх, эм найрлагыг ээлжлүүлэн хавсаргаж хэрэглэх гэх мэтээр олон зүйл бий. Энэхүү өвчнийг үүсгэх нөхцөл нь манай өнөөгийн амьдралын хэв маяг, үйл явдал, идээ ундааны дадлагатай ойртож ирж байгаатай холбоотой. Уламжлалт анагаах ухааны эм найрлагын үйлдлийг сайтар судалж, цөсний өвчний үед хэрэглэдэг эм найрлагыг хураангуйлан, цөсний өвчний эмчилгээ ба урьдчилан сэргийлэхэд ач холбогдолтой учир энэхүү судалгааг хийх үндэслэл боллоо. **Зорилго:** Цөсний өвчний үед хэрэглэдэг уламжлалт анагаах ухааны эм найрлага, жор судлалын талаар судлан үзэх. **Арга, аргачлал:** Анагаах ухааны дөрвөн үндэс, түүний тайлбар, сурвалж бүтээлүүдийг түүвэрлэж, герменевтик арга зүй, эх бичиг сурвалж судлалын харьцуулах арга, түүхийн төрөлжүүлэлтийн арга, анализ-синтезийн арга буюу задлан шинжилж, нэгтгэн дүгнэх аргачлал ашигласан. **Үр дүн:** Цөсний өвчнийг анагаах нийт 43 жор найрлагыг сурвалж бичгээс түүвэрлэн авсан. Засах аргын үүднээс ялгахдаа бүгд адилхан халуун хүйтэн гэж ялган засах арга бичигдсэн байв. Манаг рэнчинжунай-д цөсний халуун өвчний эм найрлыг ангилалгүй бичигдсэн байв. Рашааны дусалд шинэхэн ба хуучин гэж хоёр ялган жороо тайлбарлав. Бусад сурвалж бүтээлд бичигдсэн зүйл нь Анагаах ухааны дөрвөн үндэстэй ижил утгатай байлаа. Анагаах ухааны дөрвөн үндсэнд хураах эм, туулга, өвчний үлдвэрийг нядлах, халууны урхаг хоцорсон үед өгөх эмийг маш тодорхой тайлбарласан. Засал, идээ ундаа, явдал мөр нь сурвалж бүтээлүүдэд ялгаагүй байв. Увдисын үндэсний нэмсэн аргад тарниар засах арга бичигдсэн нь бусад тайлбар бүтээлүүдээс ялгаатай байв. Манаг рэнчинжунай-д цөсний хүйтэн өвчний эм, найрлагыг ангиалалгүй бичигдсэн байв. Рашааны цагаан шүүдэрт эмийн хэмжээг нарийн тоочив. Засал нь увдисын үндэсний нэмсэн арга ба дөрвөн рашаанд ханах ба туулгыг нэмж тайлбарлав. Идээн ундаа, явдал мөрын талаар манаг рэнчинжунайд бичигдээгүй бол бусад сурвалж бүтээлүүдэд ялгаа үгүй ижил байлаа. **Дүгнэлт:** Уламжлалт тайлбар бүтээлүүдээс цөсний өвчнийг анагаах олон жор илрүүлснээс цөсний халуун өвчнийг анагаах жор болоод дан эмийн тоо нь цөсний хүйтэн өвчнийг анагаах эм найрлагатай харьцуулахад олон байна.

Үндэслэл: Монголын уламжлалт анагаах ухаан нь монгол хүний бие махбод, оюун санаа, сэтгэлзүйн онцлог, ёс заншилтай зохицсон, өөрийн өвөрмөц онцлог шинж чанар, онолын системтэй биеэ даасан анагаах ухаан юм. Монгол үндэстний ард түмний эрүүл мэндэд хувь нэмрээ үзүүлж ирсэн бөгөөд урт удаан хугацааны түүхэн хөгжлийн явцад өв уламжилсаар ирсэн. Хөгжлийн явцад амьтан, үрийн зүйл, ургамлын эмт бодисын мэдлэг аажмаар нэмэгдэн хуримтлагдсаар эм найрлага болох суурь тавьсан байна¹. Уламжлалт анагаах ухааны тулгуур бичиг “Анагаах Ухааны Дөрвөн Үндэс”-ийн Онолын Үндэст өвчин эмгэгийг анагаах ерөндөг нь: явдал мөр, идээ ундаа, эм, засал гэж дөрөв бий хэмээсэн. Идээ ундаа, явдал мөрт: биеийн эрүүл ахуйд тустай идээ явдлыг тэнцүүлэхэд хэзээд анхаарал тавьж байвал өвчин үүсэхгүй гэдэг. Эм найрлага нь хий шар бадганы сургаал ба таван махбодын сургаалаар удирдамж болгож, өвчнөөс урьдчилан сэргийлэх, анагаах зэрэг бүхэл цогц үзлийг баримталж эмнэн засахад гол үйлдэл үзүүлж буй юм². Уламжлалт анагаах ухааны эм найрлага нь эмт ургамал ургах зохих газартаа ургасан, түүвээс зохистой цагт нь түүсэн, эмийн хорыг гаргах, сайтар хагаах, үл хуучруулах, эмийг номхотгох, эмийг зохицуулан найруулах зэрэг эрхэмлэх долоон гишүүнийг баримталж, амт, чанар, чадал, шингэлтийн онцлогийг үндэслэж найруулжээ³.

Өвчний байдлыг үндэслэн эм хэрэглэх арга зам нь эм уулгах, эм шавах, эм түрхэх, эмээр угаах, шулуун гэдсээр эм тавих, эм дусаах, эмээр зайлах, эм соруулах, эмээр утах, дэвтгэлгэ, жин тавих, улиралтайгаа тохируулан хэрэглэх, цагийг тохируулан хэрэглэх, эм найрлагыг ээлжлүүлэн хавсаргаж хэрэглэх гэх мэтээр олон зүйл бий³. Ийнхүү Онолын Үндэст: Дэлхий дэх аливаа бодис таван махбодоос үүсэж, зургаан амтнаас бүрддэг болохоор ямар нэгэн бодисын амт чанарыг мэдэж таньж, найруулж чадвал эм болгон хэрэглэж болно гэв². Монгол эм нь хүний биеийн өвөрмөц онцлог ба биеийн гурван махбод хий, шар, бадгантай уялдуулж, өглөө хийн цаг, үд шарын цаг, орой бадганы цаг гэж ялган эм өгч, бүхэл цогцын үзлийг баримтлан, байгаль ахуйтай нэн сайхан зохицсон байна. Мөн монгол эмийн уух хэмжээ нь бага, эмийн гаж нөлөө бага, ууж хэрэглэхэд хялбар, авч явахад хялбар зэрэг сайн талтайгаас гадна олон жилийн эмчилгээний туршид ард олонд таашаагдсан байна. Уламжлалт анагаах ухааны сурвалж бүтээлүүдэд цөс нь шарын ерөнхий оронд оршино. Цөсний шингэн нь шарыг үүсгэх бодисын сурвалж болох бөгөөд шингээгч шарын бодисын сурвалж мөн гэжээ. Үүнд цөс нь шарын ерөнхий оронд оршиж, шингээгч шарын гол орон мөн.

Шингээгч шар нь гэдэсний эхний хэсэгт оршиж, шингээлтийн хүч галын илч болж байдаг зэрэг нь орчин үеийн анагаах ухаан судлалд тодорхойлсон цөсний шингэн нь цөсний цоргоор дамжин арван хоёр хуруу гэдсэнд ордогтой нийцэж байна⁴. Иймээс олон талаас харьцуулбал, цөсний шингэн нь шар хийгээд шарын бодисын сурвалж болох нь тодорхой юм. Мөн ном судраас шар махбодын нэр нь анхандаа цөс гэсэн утгатай байж, Энэтхэг хэлэнд пирс, Төвөд хэлэнд рхива, Монгол хэлэнд цөсөнд, сүлсэн, сөс гэж

нэрийдэж байсан ч бүгд цөс гэсэн утгатай. Энэ тухай Увдисын үндсэнд: шар өвчний шалтгаанд өвчний суурь нь цөс болно гэж илтгэж, цөсний өвчнийг дангаар нь тайлбарлаагүй, харин шарын өвчинд тайлбар хийсэн байна. Иймээс цөсний гол үйл ажиллагаа нь тунгалаг цөвийн ялгаралтад оролцож, шингээлтийн гурван хүчний голлогч болж, идээ ундааг шингээж, биеийн илчийг ихээр үүсгэнэ^{2,5}.

Цөсний өвчлөлийн нөхцөл нь “Жидүйнинор”-т оньсон газар шарагдах, доргисон, халуун исгэлэн идээ ундаа ба хоорондоо үл зохилдох идээ ундаа, эс шингэсэн, уурласан, ариун цэврийг хамгаалаагүй зэргээс өвчин үүснэ гэж ялгамжтай тайлбарласан юм⁶. Энэхүү өвчнийг үүсгэх нөхцөл нь манай өнөөгийн амьдралын хэв маяг, үйл явдал, идээ ундааны дадлагатай ойртож ирж байгаатай холбоотой. 2019 оны байдлаар Монгол улсын хүн амын Эрүүл мэндийн үзүүлэлтээр хоол боловсруулах тогтолцооны өвчин өвчлөлийн 2 дугаарт орж цөсний хүүдий, цөсний зам ба нойр булчирхайн өвчин 14.2%-ийг эзэлж дээрх өвчлөлтэй хамааралтай мэс заслын эзлэх хувь өндөр байна⁷. Ийнхүү уламжлалт анагаах ухааны эм найрлагын үйлдлийг сайтар судалж, цөсний өвчний үед хэрэглэдэг эм найрлагыг хураангуйлан, цөсний өвчний эмчилгээ ба урьдчилан сэргийлэхэд ач холбогдолтой нь энэхүү сэдвийг сонгох үндэслэл болсон.

Зорилго: Цөсний өвчний үед хэрэглэдэг уламжлалт анагаах ухааны эм найрлага, жор судлалын талаар судлах.

Арга, аргачлал: Анагаах ухааны дөрвөн үндэс, түүний тайлбар, сурвалж бүтээлүүдийг түүвэрлэж, Сурвалж судлалыг герменевтикийн аргаар өвчин зүйн ойлголт, үг утгын оноолтыг хийж, эх бичгийн судалгааг харьцуулах аргаар жор найрлага харьцуулан, анализ-синтезийн аргаар бүхэл цогц оюун дүгнэлт хийнэ.

Герменевтик арга зүй: Герменевтик арга зүйн гол баримтлал бол зохиогчийн гол зорилт харин нуугдмал утга санааг өөрийнхөө оюунаар илрүүлж болох явдал юм. Ер нь шинжлэх ухааны онолын судалгаа нь их төлөв баримт дүгнэлтүүдийн утгыг тайлах, тодорхойлох, тайлбарлахад чиглэсэн байдаг. Өөрөөс нь илүү ойлгож болох буюу зохиогчийн ухамсарлаж бодоогүй, гол зорилт болгон тавиагүй далд нуугдмал утга санааг илрүүлж болох явдал юм. Энэхүү арга зүйгээр халдварт өвчний зүйлүүдийн гарал үүсэл, далд утга, давхар санаа, агуулгын хүрээ, нэр томьёо ижил ч утга ижил, нэр томьёо ондоо ч утга нэг байдлуудыг судлан тогтоох зэрэгт ашиглах болно^{8,9}.

Эх бичиг сурвалж судлалын харьцуулах арга: Энэ аргын мөн чанар нь эх бичиг сурвалж судлалын үйл явдал, үзэгдэл, явцын хооронд нь харьцуулан судалснаар тэдгээрийн адил төстэй шинж чанар, ялгаатай талыг бодит байдлаар тогтоох боломжийг олгодог арга. Харьцуулалтын үр дүн хоёр ба түүнээс дээш объектын нийтлэг зүйлийг тогтоохын зэрэгцээ, давтагдаж байгаа ерөнхий зүй тогтлыг илрүүлж, энэ үндсэн дээр түүний мөн чанар, учир зүйг танин мэдэх боломжтой болно. Харьцуулалтыг судалж байгаа зүйлийн мөн чанарыг

баримтад түшиглэн мэдэх, баримтыг тайлбарлах, дотоод шинж чанарыг ерөнхий, давтагдах, ижил төстэй, ялгаатай, чухал зүй тогтлыг олж харах, түүнчлэн ижил төстэй зүйлүүд боловч агуулгаараа ялгаатай байгааг харьцуулан судлах боломж олгодогт оршино^{8,9}.

Түүхийн төрөлжүүлэлтийн арга: Үзэгдэл хийгээд объектуудын бүрдлийг тэдгээрийн нийтлэг гол шинжүүдэд нь үндэслэн тодорхой төрөл болгон цэгцлэх зорилготой шинжлэх ухааны танин мэдэхүйн аргыг төрөлжүүлэлт гэнэ. Индукц /үндэслэлийг нэгтгэж ерөнхийлөн дүгнэх/, дедукц /өөрчлөн нотлох, ерөнхийд тулгуурлан онцгойг нотлох/ буюу нэгтгэн дүгнэх, өөрчлөн нотлох хандлагын /арын/ үндсэн дээр түүхийн төрөлжүүлэлтийн арга нь бодитой болно^{8,9}.

Анализ-синтезийн арга буюу задлан шинжилж, нэгтгэн дүгнэх арга: Задлан шинжилж, ялган салгаж, гэсэн утгатай бөгөөд судлаач сонгож авсан объект буюу юмс үзэгдлийг өөрийн сэтгэхүйгээр тодорхой бүрэлдэхүүн хэсгүүдэд задлан хуваана. Ингэснээр тухайн объектын хийсвэрлэж болох үндсэн шинж чанарууд тодорхой бүрэлдэхүүн хэсгүүд дээр илүү тод илэрч гардаг. Анализ хийж объектыг задлан шинжилснийг шууд дагалдаж, зайлшгүй хийгддэг сэтгэхүйн логик үйлдэл юм. Судалгааныхаа объектыг бүрэлдэхүүн хэсгүүдэд задлан хувааж, хэсэг тус бүрийн шинж чанарыг тодотгосныхоо дараа тэдгээрийг сэтгэхүйдээ эргэн нэгтгэж, бүхэл цогц оюун дүгнэлт төсөөллийг үүсгэнэ. Энэ үйлдэл нь синтез юм^{8,9}.

Синтез-анализын арга: Аливаа объектын шинжлэх ухааны танин мэдэхүй буюу судалгаа ихэвчлэн түүнийг задлан шинжлэхээс эхэлдэг. Анализ гэж судалгааны объектыг хийсвэр сэтгэхүйгээр, түүний бүрдэл хэсэг, тусгай шинж, талуудаар ангилан салгаж судалдаг арга юм. Харин анализ бол судалгааны эцсийн


зорилго биш, тэр нь бүхлийг нөхөн сэргээх, түүний дотоод бүтэц, үйлчлэлийн шинж, хөгжлийн хуулийг ойлгож мэдэхийг эрмэлзэж байдаг. Энэ зорилго дараах онолын синтезээр хэрэгждэг. Синтез-анализын аргаар таньж мэдсэн бүхлийн хэсэг, тал, холбоо зэргийг хийсвэрлэлийн замаар бүхэл болгон нэгтгэн дүгнэж танин мэдэх арга юм^{8,9}.

Түүхэн харьцуулах арга: Уламжлалт анагаах ухааны эртний ном судраас хайж олсон эм найрлага ба одоо үеийн арвин хэрэглэгдэж байгаа эм найрлагыг хооронд нь ямар ялгаатай байхыг харьцуулж, эмнэлгийн арга зүй нь хэрхэн уламжилж ирснийг илрүүлэхэд энэхүү аргыг хэрэглэнэ^{8,9}.

Статистик боловсруулалт: Судалгааны ажлын үр дүнгийн боловсруулалтыг хийхдээ судалгаанд авсан эх сурвалжуудаас холбогдох баримтуудыг түүвэрлэн авч, бусад эх сурвалжуудаар баталгаажуулалт, хэлэлцүүлэг хийж баталгаажуулна. Мэдээ, материалыг кодлон түүвэрлэж текст хэлбэрээр бичиж оруулав. Мэдээллийг зорилтот бүлэг бүрээр нэгтгэн, агуулга утга санаа, ижил төстэй санаа, агуулгын харилцан хамаарал зэргээр дугаарлан нэг дараалалд оруулав. Дараа нь үр дүнг нэгтгэн, харьцуулж, эрс тэс ялгааг илрүүлж тайлбарлана. Статистик боловсруулалтыг SPSS22.0 программ ашиглаж хийж гүйцэтгэв.

Үр дүн: Нийт найрлагыг дүгнэн үзвэл ерөнхий ялгал, язгуурын ялгалын орон нь увдасын үндэсний нэмсэн арга, алтанчимэг, хөх биндэрьяа, жидүниннор зохиол сурвалж нь цөсний өвчнийг дурдахдаа анагаах ухааны дөрвөн үндэстэй адил утгатай байв. (Зураг 1)


Цөсний өвчний дан эмийн 21 жагсааж, цөсний халуун өвчний дан эм 14 байж, 1 чихрийн хөлөгтэй. Цөсний хүйтэн өвчний дан эм 6 байна. Эдгээр дан эмийг эмийн аймагт төрөлжүүлсэн. (Зураг 1)



Зураг 1. Цөсний өвчний дан эмийг эмийн аймгаар төрөлжүүлсэн дүн

Цөсний өвчний жорыг 43-г жагсааж, цөсний халуун өвчний жор 30 байна. Цөсний хүйтэн өвчний

жор 10 байна. Туулбар 3 байна. Эдгээр жорыг эм найрлагын хэлбэрээр төрөлжүүлсэн. (Зураг 2)



Зураг 2. Цөсний өвчний жор найрлагын эмийн хэлбэрээр төрөлжүүлсэн дүн

Манагрэнчинжунай сурвалж бичиг нь зөвхөн жор бичигдсэн, засал, идээ ундаа, явдал мөр, тарни заслыг дурдаагүй сурвалж бичиг байв. Судалгаанд багтсан сурвалжаас ганцхан увдисын үндэсний нэмсэн арга сурвалж бичигт дөрвөн ерөндөг дээр нэмээд тарни заслыг дурдсан байгаа нь онцгой байв. Анагаах ухааны

дөрвөн үндэс, увдисын үндэсний нэмсэн арга, дөрвөн рашаан, алтан чимэг, хөх биндүрээ, жидүй нинор сурвалж бичгүүдэд эм, засал, идээ ундаа, явдал мөрийн заслын талаар ижил төстэй дурдагдсан байна^{2,10-13}. (Хүснэгт 1)

Хүснэгт 1. Цөсний өвчний эмчилгээг ном сударт тэмдэглэснийг харьцуулсан байдал

	Анагаах ухааны дөрвөн үндэс	Увдисын үндэсний нэмсэн арга	Дөрвөн рашаан	Алтан чимэг	Хөх биндүрээ	Манагрэнчин Жунай	Жидүй Нинор
Эм	дан эм жор	дан эм жор	дан эм жор	дан эм жор	дан эм жор	жор	дан эм жор
Засал	ханах төөнөх	ханах төөнөх	ханах төөнөх	ханах төөнөх	ханах төөнөх	дурдаагүй	ханах төөнөх
Идээ ундаа	хөнгөн, сэрүүн зүйл ба шинэ зөөлөн зүйл	хөнгөн, сэрүүн зүйл ба шинэ зөөлөн зүйл	хөнгөн, сэрүүн зүйл ба шинэ зөөлөн зүйл	хөнгөн, сэрүүн зүйл ба шинэ зөөлөн зүйл	хөнгөн, сэрүүн зүйл ба шинэ зөөлөн зүйл	дурдаагүй	хөнгөн, сэрүүн зүйл ба шинэ зөөлөн зүйл
Явдал мөр	сэрүүн ба хуурай газар сувилна	сэрүүн ба хуурай газар сувилна	сэрүүн ба хуурай газар сувилна	сэрүүн ба хуурай газар сувилна	сэрүүн ба хуурай газар сувилна	дурдаагүй	сэрүүн ба хуурай газар сувилна
Тарни засал	дурдаагүй	НАМО ХЭДҮ ДҮХЭ СУУХА хэмээн саявийг дэвтээсэн усанд тарнидаж өгнө.	дурдаагүй	дурдаагүй	дурдаагүй	дурдаагүй	дурдаагүй

Цөсний өвчний тухай эмийн сударт бичихдээ цөс бол цөсний өвчний алинд ч тустай. Амьтны цөсийг ардын эмнэлэгт ямар зорилгоор ашиглаж байдгийг судар бичгийн тоймоос анализ хийж үзвэл ихэнх сурвалжинд шарх, халуун, нүдний өвчин, найруулсан хорыг арилгах зэрэгт хэрэглэж байгаа талаар дурдсан байна. Судасны амыг боож, илжрэхийг таслан, махыг

эдгээх, хорыг арилгаж нүдэнд тустай гэж тэмдэглэсэн байв. “Эмийн Хиргүй Болор эрх” номонд дурдахдаа амьтны цөсний аль нь ч сэрүүн чанартай тул цөсний шар өвчнийг арилгана гэж тэмдэглэв. “Цагаан болор толь”-д цөсний зүйл бүхэн судлын амыг боож, илжрэхийг зогсоох, махыг сэлбэх бөгөөд хорыг арилгаж нүдэнд туслах болно гэв. (Хүснэгт 2)

Хүснэгт 2. 16 амьтны цөсийг ном судраас олж, амьтны язгуураар хувааж дурдав¹⁴⁻¹⁸⁻²⁰

Эмт бодисын нэр	Амьтны язгуур	Чадал
Баавгайн цөс	Баавгайн язгуурын араатан амьтан	цөсний дээд мөн. Судасны амьг барина.
Зааны цөс	Зааны язгуурын амьтан	хороор мах хатаж шуугдсанд хорын эмтэй найруулж өг. Урт үст зарааны уушгитай найруулж, булчин задрахыг дарна.
Зэрлэг сарлагийн цөс	Үхрийн язгуурын амьтан	хэнхдэг цээжний судсыг боож, элгийг үүсгэнэ.
Алаг тахиан цөс	Тэжээвэр амьтан	тогосын өндгөнд найруулсан хорыг арилгана.
Гүрвэлийн цөс	Гүрвэлийн язгуурын амьтан	толгойн махыг үүсгэнэ.
Хар мэлхий ба тотийн цөс	Мэлхийн язгуурын амьтан	найруулсан хорыг арилгана.
Тарвагын цөс	Хөхтөн амьтан	найруулсан хор ба шарханд тустай бөгөөд архины өвчнийг арилгана.
Тасын цөс	Харцгайн язгуурын шувуу	нүдийг тодруулан шархыг анагааж уушгины өвчинг арилгана.
Хонь, малын цөс	Хөхтөн амьтан	шарханд тустай.
Ямааны цөс	Үхрийн язгуурын амьтан	хорхой тасалж, өвчиний хор сарнисныг арилгана.
Хар үхрийн цөс	Үхрийн язгуурын тэжээвэр үхэр	найруулсан хор нүдэнд туссан өвчинд тустай.
Загасны цөс	Усны амьтан	шархны халуун ба нүд бүрэлдэхэд тустай. Загас тэргүүтэн усанд оршдог амьтны цөс галд халсаныг сэргээнэ.
Гахайн цөс	Гахайн язгуурын амьтан	шархны хор халууныг арилгаж, нүдэнд тустай.
Гунжин үнээний цөс	Хөхтөн амьтан	солио өвчнийг арилгана.
Хулганы цөс	Хөхтөн амьтан	шархны хийг арилгана.
Аварга могойн цөс	Могойн язгуурын амьтан	өвчин бүхнийг арилгахад тустай.

Хэлцэмж: Уламжлалт анагаах ухааны сурвалж тайлбар бүтээлүүдэд цөсний өвчнийг халуун, хүйтэн хоёр зүйлээр төрөлжүүлэн, анагаах жор найрлагыг дан эмийн болон олон найрлагат хэмээн томъёолсон байна. Анагаах ухааны дөрвөн үндэст хураах эм, туулга, өвчний сүүлийг таслах, халууны урхаг хоцорсон үед өгөх эмийг маш тодорхой оновчтой бичсэн болно.

Судлагдахууны эх хэрэглэгдэхүүний хүрээнд харьцуулж шинжлэхэд ерөнхийдөө “Анагаах ухааны дөрвөн үндэс” сурвалжийг баримталсан байна. Харин Манаг ренчинжунай цөсний өвчнийг анагаах найрлагыг ангилалгүй бичсэн бол Рашааны дусалд шинэ хуучин хэмээн ангилан бичсэн, Увдисын нэмсэн арга бүтээлд тарни заслыг нэмж дурдсан нь ялгаатай байлаа. Цөсний өвчнийг анагаах олон төрлийн эмт найрлагыг эртний сурвалж бүтээлүүдэд оновчтой тодорхой дурдсан нь өнөөгийн анагаах ухааны практикт чухал ач холбогдолтой юм.

Дүгнэлт: Уламжлалт тайлбар бүтээлүүдээс цөсний өвчнийг анагаах олон жор илрүүлснээс цөсний халуун өвчнийг анагаах жор болоод дан эмийн тоо нь цөсний хүйтэн өвчнийг анагаах эм найрлагатай харьцуулахад олон байна. Уламжлалт тайлбар бүтээлүүдээс харьцуулсанд Анагаах ухааны дөрвөн үндэс сударт бүрэн гүйцэд тайлбар хийсэн байна.

Ном зүй:

1. Лунрэгдандар. Монгол уламжлалт анагаах ухааны түүх. 2017.
2. Ёндонгомбо Ю. Анагаах ухааны дөрвөн үндэс. 1992:214-228.
3. Багана ЖБЖ, Бай Мей Рун Монгол анагаах ухааны эм найрлага. 2011:39-48.
4. минг Жя. Цөсний үйл ажиллагааны эмнэлзүйн хэрэглээний анатоми ба мэс заслын аргууд. 2020:317-320.
5. Б.Жигмэд. Монгол анагаах ухааны үндсэн онол. 2014 183-304.
6. Лувсанчоймтл. Жидүйнинор. 2005:15-25.
7. https://erdemed.com/clinic/acute_cholecystitis/
8. Жадамба Б ЧЦ. Судалгааны арга зүй. 2011:50-53,64-70.
9. Сувд Н МБ, Дэмбэрэлсүрэн Ж. Эрүүл мэндийн судалгааны арга зүй. 2001.
10. Санжаажамц Д. Увдисын үндэсний нэмсэн арга. 1992
11. Лувсанчойдог Дм. Алтанчимэг. 2015:31.
12. Санжаажамц Д. Хөх Биндэрьяа. 2016:582.
13. прнлэй Жд. Манаг Рэнчинжунай. 2016:18.
14. Ц.Хайдав. Ардын эмнэлэгт хэрэглэж байсан амьтны гаралтай эм. 1982.
15. тойн Н. Үзэсгэлэнт нүдэн чимэг, Төвөд модон барын судар. 305-366.
16. Данзанпунцаг. Эмийн хир үгүй болор эрхи. 2019 486.
17. Оюунчимэг. Монгол судлалын нэвтэрхий толь. 2015:247-977.
18. Ишбалжир СХ. Цагаан болор толь. 2019:165.

Analysis of the ingredients of traditional medicine recipes for gallbladder disease

Khunaa (Zhao zhi hong)¹, Munkhchimeg O², Shilentsetseg B³, Batnairamdal Ch²

¹MNUMS, International School of Mongolian medicine

²MNUMS, Central Hospital of Mongolian Medicine

³China, Inner Mongolia Medical University

E-mail: btd24ee009@gt.mnumns.edu.mn, Tel: +976-85153367

Background: As of 2019, according to the Health Indicators of the Mongolian population, diseases of the digestive system ranked second in terms of morbidity, with gallbladder, biliary tract, and pancreatic diseases accounting for 14.2%, and the proportion of surgeries related to these diseases is high.

Aim: Explore the ingredients and recipes of traditional medicine used for gallbladder disease.

Materials and Methods: “The four foundations of medicine-Анагаах ухааны дөрвөн үндэс” and their interpretations, and source works were selected, and hermeneutic methodology, comparative method of source studies, historical classification method, and analysis-synthesis method were used.

Results: A total of 43 recipes for treating gallstone disease were selected from the source texts. In terms of the method of treatment, all of them were written as hot and cold. The medicine for gallstone heat disease was directly written in “Manag Renchinjunai-Манар рэнчинжунай”. The two recipes were explained as new and old in the “Four springs-Рашааны дусал”. Although the contents written in other source books are the same as “The four foundations of medicine-Анагаах ухааны дөрвөн үндэс”, the “The four foundations of medicine-Анагаах ухааны дөрвөн үндэс” are very clearly explained as medicines to be taken, decoctions, and medicines to be given when the effects of heat are delayed. There is no difference in the following books and sutras regarding treatment, food and drink, and events. The method of adding mantras to the national method of Uvdis is not written in other sutras. The medicine for gallstone cold disease was directly written in “Manag Renchinjunai-Манар рэнчинжунай”. The amount of medicine in the “Four springs-Рашааны дусал” was carefully calculated. “The four foundations of medicine-Анагаах ухааны дөрвөн үндэс” are astringent, emetic, laxative, stopping the tail of the tail, and cutting off the tail of the disease and replacing it. The method of treating the disease is a method of adding charms to the root, and the “Four springs-Рашааны дусал” are also explained. The food and drink and the event are not written in the Манар рэнчинжунай, and there is no difference in other books and scriptures.

Conclusion: While many recipes for treating gallbladder diseases have been discovered in traditional treatises, the number of recipes and medicines for treating gallbladder heat diseases is greater than the number of medicines for treating gallbladder cold diseases.

Keywords: Bile-heat disease, Bile-cold disease, Explanatory works, Single medicine, Ancient sources